### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ шинэчлэн баталсан.
- ЗГ-ын 2023 оны 301 дүгээр тогтоолоор "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журам" баталж 9 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн.
- ЗГ-ын 442-р тогтоолоор Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын тав дугаар бүлэгт өөрчлөлт орж 12 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн байна.
- ЗГ-ын 203 дугаар тогтоолоор "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай журам" тогтоолууд шинэчлэн батлагдсан байна.
- ЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 19-ны 382 дугаар тогтоолоор баталсан журамд өөрчлөлт оруулах журмын 5 дахь заалтад ЗГ-ын 2022 оны 489 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орж 2023 оны 1 дүгээр сарын 2-оос хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/97 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42,640.2 мянган төгрөгөөр буюу 9.7 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	634.2	-	634.2
Урьдчилгаа	-	--	-
Бараа материал	355,892.8	315,517.9	-40,374.9
Үндсэн хөрөнгө	80,620.3	164,269.7	83,649.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>437,147.4</b>	<b>479,787.7</b>	<b>42,640.2</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	437,147.4	479,787.7	42,640.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>437,147.4</b>	<b>479,787.7</b>	<b>42,640.2</b>

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 40,374.9 мянган төгрөгөөр буурсан нь 92,464.4 мянган төгрөгийн хангамжийн материал акталж устгасантай холбоотой байна. Тайлант онд худалдан авсан бараа материал 238,943.1 мянга, шатахууны урамшуулалт 752.0 мянга, нийт 239,695.1 мянган төгрөг нэмэгдэж, үйл ажиллагаанд 187,605.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй байгаа болон их хэмжээгээр худалдан авч нөөцөлсөн материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 83,649.4 мянган төгрөгөөр өссөн. Тайлант онд худалдан авалт 5,000.0 мянга, НЗДТГ-аас шилжиж ирсэн Налайх дүүрэгт байрлах 101,700.0 мянган төгрөгийн 3000 м<sup>2</sup> газар, нийт 106,700.0 мянган төгрөг нэмэгдэж, акталж устгасан 36,454.9 мянган төгрөг хасагдаж, элэгдлийн зардалд 23,050.6 мянган төгрөг тооцсон байна. Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 42,640.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 636,527.7 мянга, нийт зарлагыг 636,527.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 84,448.9 мянган төгрөгөөр бууруулж 552,078.8 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: Эд хогшил, урсгал засварын зардлыг 107,300.0 мянга, томилолт зочны зардлыг 50,000.0 мянга, байр ашиглалттай холбоотой зардлыг 9,783.9 мянга, бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 9,400.0 мянга, нийт 176,483.9 мянган төгрөгөөр бууруулж, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл 92,035.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Энэ нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой эд хогшил, урсгал засварын зардал болон хангамж бараа материалын худалдан авалтын зардлыг бууруулсан ч цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг цалин хөлс нэмэгдүүлэх шийдвэр тогтоомжтой холбогдуулан 21,281.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 573,359.9 мянган төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 488,441.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, өөрийн орлого 30,122.0 мянга, нийт 518,563.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 518,563.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 518,563.9 мянган төгрөг буюу 90.4 хувьтай байгаа нь цалин хөлс 49,083.7 мянга хангамж бараа материалын зардал 5,712.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /мянган төгрөгөөр/
1	71713 хөтөлбөр	573,359.9	518,563.9	54,795.9	90.4
1.1	80101 арга хэмжээ -Үндсэн үйл ажиллагааны зардал, цалин хөлс, ашиглалтын зардал	568,359.9	513,631.2	54,728.7	90.4
1.2	80802 арга хэмжээ – урсгал шилүүлэг, шагнал урамшуулал, буцалтгүй тусламж	5,000.0	4,932.7	63.7	98.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд НЭД-ийн захирамжаар хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 1,176,984.0 мянган төгрөгийн санхүүжилт оржээ. Үүнээс цалин урамшуулал, НДШ-ийн

зардалд 76,383.3 мянга, томилолт зочны зардалд 1,249.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 1,040,975.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 35,000.0 мянга, нийт 1,153,608.1 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 23,375.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэнийг санхүүжилт бууруулан тайлагнасан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн авлага, өр төлбөрийн үлдэгдэлгүй байх, анхан шатны маягт хөтлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн ахлах аудитор Ё.Лхагвадулам, аудитор Б.Тэгшлхам нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.ТҮвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Цагдаагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 1,171,539.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 23,430.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж өхөнцөн төслийн холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсрал ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад хөрөнгө худалдан авалт, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг 54,795.9 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан эсэхийг гүйцэтгэлийн тайлан болон судалгаанаас дүгнэж үзэхэд дэд дарга, орлогч дарга, зөвлөх албан тушаалын орон тоогүй, бараа материалын худалдан авалтын төсөв буурсан, ашиглалтгүй болон нөөцөлсөн бараа материал байхгүй, давхардуулан олгосон тэтгэмж урамшуулал байхгүй, гар утасны төлбөрт зардал гаргаагүй, байгууллага хамт олныг сурталчилсан видео контент хийгээгүй, байр талбайн ашиглалтын зардал тохируулгатай тоолуур ашигладаг байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлбэл зохих 3,642,304.3 мянган төгрөгийн 117 мэдээллээс 117 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАУХАТХ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг үзэхэд хөрөнгийн худалдан авалтад материаллаг хэмжээний зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцэж байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 124,179.1 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 4 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,152.7 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	3,152.7	4	3,152.7	100.0
Нийт дүн	4	3,152.7	4	3,152.7	100.0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд 36,933.8 мянган төгрөгийг тээвэр, шатахууны зардалд зарцуулсан үүнээс дуудлагын автомашинд 7,787.2 мянга, нэмэлт санхүүжилтийн арга хэмжээнд Сити тур аялалын автобусанд 29,146.6 мянган төгрөг байна. Дараагийн аудитаар анхаарах асуудлаар тээврийн зардал, шатахууны зарцуулалтын түүний үр өгөөжийн талаар үзэхээр тооцон төлөвлөв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,764.0 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 3 зөвлөмж өгсөн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт-1: Нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөр арга хэмжээний төсвийн задаргаагүй багцаар баталсан, төсвийн зарцуулалтын тайлангүй, тодорхой төсөвлөгөөгүй нэмэлт ажилд 18,405.0 мянган төгрөг зарцуулсан нь төсөв хяналтгүй, үр ашиггүй зарцуулагдах үр дагавар бий болгосон байна. Энэ нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлээгүй, "Үнэлгээ ба хуваарилалт", "Иж бүрэн байх" "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх, хөтөлбөр арга хэмжээнд төсөв баталж, төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Илрүүлэлт-2: "Эрүүл Монгол хүн" төслийн шинжилгээний багцтай давхцуулан, албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан 1,759.0 мянган төгрөг зарцуулсан нь төсөв хяналтгүй зарцуулах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" заалт хэрэгжээгүй.

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай төлөвлөж зарцуулах.

Илрүүлэлт-3: Сити тур аяллын 2 автобусны гражын төлбөрийн гэрээний нөхцөл тодорхой бус, тайлант онд 600.0 мянган төгрөг илүү шилжүүлснийг урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй нь тайлант үеийн зардал буруу тайлагнах, ашиглалтын зардал төсөвлөгдсөнөөс илүү, хяналтгүй зарцуулагдах үр дагавартай. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бodoх бүртгэлийн журам", Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Үнэн зөв байх" заалт хэрэгжээгүй.

Өгсөн зөвлөмж: Гэрээг тодорхой нөхцөлтэйгөөр хийж, гүйцэтгэлийг дүгнэж, зардлыг тайлант үед үнэн зөвөөр тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:								Хариуцлага тооцуулах албан шаардлагага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
			Төлбөр ийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Toо	Дүн	Тоо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн	Тоо	Дүн
Нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөр арга хэмжээний төсвийн задаргаагүй багцаар баталсан, төсвийн зарцуулалтын тайлангүй, тодорхой төсөвлөгдөөгүй нэмэлт ажилд зарцуулсан	1	18,405.0					1	18,405.0				
Албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ нь "Эрүүл Монгол хүн" төслийн шинжилгээний багцтай давхацуулан 1,759.0 мянган төгрөг зарцуулсан	1	1,759.0					1	1,759.0				
Сити тур аялалын 2 автобусны гражын төлбөрийн гэрээний нөхцөл тодорхой бус, тайлант онд 600.0 мянган төгрөг илүү шилжүүлсэнийг урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй	1	600.0					1	600.0				
Дүн	3	20,764.0					3	20,764.0	-	-	-	-

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭИ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр - нийслэлийн Аялал жуулчлалын газар  
Тайлант хугацаа: 2023 он  
Аудитын код: НГАГ-2024/253/НА-СА-ТШ3

№	АГАДУТ	АГАДУТ-ИНД ДЭД АНГИ	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөгөөр/	Материал-лаг эсэх	Үр өгөжжөөр тооцох эсэх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилаал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн	Гаргасан шийдэл
							стандартын заалт	хууль тогтоомжийн заалт					
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Ажил гүүргээний аянг	Мөнгөн хөрөнгө	Нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөр арга хэмжээний төсвийг задаргаагүй багцаар баталсан, төсвийн зарцуулалтын тайллангүй тодорхой төсвөлгөөгүй нэмэлт ажилд төсвийг үр ашигтүй зарцуулсан (A/645 захирамж 8.6 сая A/421 захирамж 3.0 сая A/676 захирамж 0.5 сая A/859 захирамж 6.0 сая A/983 захирамж 0.3 сая )	18.405.0	тийм	үгүй	УСНББОУС-29 Санхүүгийн хэрэглүүр хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт MNS-6817-4 2020 стандартын 5.2.1.7.2 Их бүрэн байж-санхүүгийн тайланд егех дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал дансны үлдэгдэл тодруулыг орхигдуулалгүй тусгассан байх	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиян 20 дугаар зүйлийн 20.1.4 "учин төөвлөр бус анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх", 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бурдлагыг ажил гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгассан байх	Нягтлан бодох бүртгэл тайлгантай холбоотой	Анхан шатны бурдэл дутуу баримтаар гүйлгээ хийгүй байх хөтөлбөр арга хэмжээнд төсвөр батлаж зориулалтын дагуу зарцуулж байх			Зөвлөмж өгөх
2	Ажил гүүргээний аянг	Мөнгөн хөрөнгө	Албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг 5 хүн хамраулсан зарим шинжилгээ нь "Эрүүл Монгол хүн" төслийн шинжилгээний багцтад давхсан байна	1.759.0	үгүй	үгүй	НББОУС-1 Санхүүгийн тайллангийн толилуулга MNS-6817-4 2020 стандартын 5.2.1.7.2 Их бүрэн байж-санхүүгийн тайланд егех дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ үйл явдал дансны үлдэгдэл тодруулыг орхигдуулалгүй тусгассан байх	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиян 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бурдлагыг ажил гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгассан байх	Нягтлан бодох бүртгэл тайлгантай холбоотой	Анхан шатны бурдэл дутуу баримтаар гүйлгээ хийгүй байх хөтөлбөр арга хэмжээнд төсвөр батлаж зориулалтын дагуу зарцуулж байх			Зөвлөмж өгөх
3	Ажил гүүргээний аянг	Мөнгөн хөрөнгө	Сити тур аялалын 2 автобусны гракын төлөврийн гэрээний нөхцөл тодорхой бус тайлант онд 600.0 мянган төгрөг илүү шилжүүлсэнгүй үрдүүчилж төлсөн зардаар тооцоогүй	600.0	үгүй	үгүй	НББОУС-1 Санхүүгийн тайллангийн толилуулга MNS-6817-4 2020 стандартын 5.2.1.7.2 Их бүрэн байж-санхүүгийн тайланд егех дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ үйл явдал дансны үлдэгдэл тодруулыг орхигдуулалгүй тусгассан байх	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиян 5 дугаар зүйлийн 5.1-т "Үнэн зөв байх" СС-ын 388 дугаар тушал	Нягтлан бодох бүртгэл тайлгантай холбоотой	Анхан шатны бурдэл дутуу баримтаар гүйлгээ хийгүй байх хөтөлбөр арга хэмжээнд төсвөр батлаж зориулалтын дагуу зарцуулж байх			Зөвлөмж өгөх
Дүн				20.764.0									

Бэлтгэсэн:

Аудитор

  
Б. Тэгшлхам  
Б. Рхагвадулам  
Н. Алтанцэцэг  
Х. Түвшинбаяр  
1117145633  
УХА0612 9077278

Огноо

Танилцах зөвшөөрсөн:

  
Дарга  
Ахлах нягтлан бодлогч



Д. Батсүх  
Огноо:

Д. Уянга  
Огноо:

Аялал жуулчлалын газар

Тайлант он:

2023 он

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг /СТАУС/  
файлаар хүлээн авахад тулгасан үзүүлэлтийн нэгтгэл

Бэлтгэсэн огноо:

2024.01.24

Данс кол	Үзүүлэлт	Үлдэгдэл	дүн	Тодруулга дүн	Зөрүү	Тайлбар
Баланс	Нийт хөрөнгө эх үүсвэрийн тулгат	C1	437,147,440.44	437,147,440.44	-	
		C2	479,787,673.52	479,787,673.52	-	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээг мөнгөний эхний эцсийн үлдэгдлийн зөрүүтэй тулгах.		-	-	-	
Үр дүн	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн тайлант оны үйл ажиллагааны нийт үр дүнг Санхүүгийн байдлын тайлангаархи тайлант үеийн үр дүнтэй тулгах		42,640,233.08	42,640,233.08	(0.00)	
	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн Өмнөх оны үйл ажиллагааны нийт үр дүнг Санхүүгийн байдлын тайлангаархи эхний үлдэгдлийн тайлант оны үр дүнтэй тулгах		112,841,307.40	112,841,307.40	(0.00)	
	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн тайлант оны үйл ажиллагааны нийт үр дүнг Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангаархи тайлант үеийн үр дүнтэй тулгах		42,640,233.08	42,640,233.08	(0.00)	
	Өмнөх оны нийт үр дүнг орлого зарлагын зөрүүтэй тулгах		112,841,307.40	112,841,307.40	-	
	Тайлант оны нийт үр дүнг орлого зарлагын зөрүүтэй тулгах		42,640,233.08	42,640,233.08	-	
	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн барагийн орлого хэсэгт тусгасан үнэ төлбөргүй ирсэн барааны орлогын хүлээн зөвшөөрсөн дүнг Баарын материал. Үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн Хандиваар болон шилжүүлэн авсан дунтэй		102,452,035.00	102,452,035.00	-	
	Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын дүнг үндсэн хөрөнгийн тодруулгын элэгдлийн зардлын дунтэй тулгах		23,050,624.05	23,050,624.05	-	
	Тайлант онд хөрөнгө худалдсаны олз, гарзын дүнг үндсэн хөрөнгийн тодруулгын дунтэй тулгах		-	-	-	
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн эхний үлдэгдэл эцсийн үлдэгдлийн зөрүүг Үр дүнгийн тайлангийн элэгдлийн зардлтай тулгах		23,050,624.05	13,404,255.95	36,454,880.00	Хасагдсан YХ-ийн элэгдэл
	Мөнгөн гүйлгээний орлого Төсвийн гүйцэтгэл, нэмэлтийн эх үүсвэр хадаалалт		1,672,172,098.13	1,672,172,098.13	-	
	Мөнгөн гүйлгээний нийт зардлыг Төсвийн гүйцэтгэл. Нэмэлтийн зарцуулалттай харьцуулалт		1,672,172,098.13	1,672,172,098.13	-	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээг YAMG, CYAMG, HOYAMG-ний дүнгүүдтэй тулгах		-	-	-	
	Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдаж авсан дүнг Мөнгөн гүйлгээний тайлангийн худалдаж авсан урт хугацаат хөрөнгөтэй тулгах		5,000,000.00	5,000,000.00	-	Худалдаж авсан YХ-ийн үйл ажиллагааны зардлаар алдаатай тайлагнасан
	Шалгах баланс		-	-	-	Худалдаж авсан YХ-ийн тайландаа
	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн тайлант оны эхний үлдэгдлийг Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэлтэй тулгах		437,147,440.44	437,147,440.44	-	
	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн тайлант оны эхний үлдэгдлийг Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэлтэй тулгах		479,787,673.52	479,787,673.52	-	

	Цэвэр хөрөнгө/өмчийн			
Хөрөнгийн дахин үнэлгээ	Өмчийн өөрчлөлтийн тайланийн дахин үнэлгээний дүнг санхүүгийн байдлын тайлангийн дахин үнэлгээний нөөцийн тайлант үлдэгдлэлтэй тулгах			
	Өмчийн өөрчлөлтийн тайланийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дүнг санхүүгийн байдлын тайлангийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтэй тулгах			
	Дт Биет бус хөрөнгө Kt/Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг/ Дахин үнэлгээний зардал/гарз/	146.200.000.00	146.200.000.00	- газар
	Дахин үнэлгээ дэлгэрэнгүй бүртгэлээр Дахин үнэлгээ СБТ/ӨӨТ	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайланийн үзүүлэлтийн тулгант	Төсвийн гүйцэтгэлийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг мөнгөн гүйлгээний болон нэмэлт санхүүжилтийн нийт орлоготой тулган шалгах	518.563.949.05	518.563.949.05	-
	Төсвийн гүйцэтгэлийн зарлагын дүнг Мөнгөн гүйлгээний зарлагын дүн. Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн зарлагын дунтэй тулгах	518.563.949.05	518.563.949.05	-
	Нийт зарлагыг санхүүжүүлэх батлагдсан төлөвлөгөө гүйцэтгэлийг тулгах	573.359.900.00	518.563.949.05	54.795.950.95
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийг тулгах	573.359.900.00	518.563.949.05	54.795.950.95
				MX үлд. буцаан төвлөрүүлэлт Мөнгөн хөрөнгө үлдэгдэл+ буцаан төвлөрүүлсэн

Бэлтгэсэн:

Аудитор

Зөвшөөрсөн:

Нягтлан бодогч

Б Тэгшлхам

Д Уянга